

НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2022.12.24

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /НТОЗШША/-ны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

НТОЗШША-ны 2022 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Сайдын зөвлөлийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **87.8%**-тай үнэлэгдсэн.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. НТОЗШША-ны даргын 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
19	10	1	8	-	-	-	-	86.8%

НТОЗШША нь 2022 онд 19 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нийт 19 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 10 арга хэмжээ, 90%-ийн биелэлттэй 1 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 8 арга хэмжээ, хэрэгжилт дунджаар 86,8%-тай байна.

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

1/ 1.2. Нислэгийн зөрчлийг бүртгэх мэдээлэх, цахим хуудасны үйл ажиллагааг шинэчлэн сайжруулна. /Жилийн эцсийн байдлаар: Мэдээллийг цахимжуулах цахим хуудасны үйл ажиллагааг сайжруулж шинэчилсэн байна/

Биелэлт: Цахим хуудсыг дотоод нөөц бололцоог ашиглан шинээр хийлгэх ажиллагаа явагдаж байна. Цахим хуудсанд орох мэдээлэл, ашиглах зарчим, шаардлагатай үзүүлэлт зэргийг бэлтгэн өгч байна.



Мэдээлэл өгөх, авах ажиллагааг бүрэн цахимжуулах, ECCAIRS програмтай холбох, албан болон сайн дурын мэдээ хүлээн авах ажиллагааг хурдан шуурхай, нууцлалын баталгаатай болгож сайжрууллаа.

Аюулгүй ажиллагааг сайжруулах зорилго бүхий осол, зөрчлийн мэдээллийн санг үүсгэх програмыг Update хийн сайжруулж, мэдээлэлд дүн шинжилгээ хийн ажиллаж байна. 70%

2/ 2.3. “Чингис хаан” ОУНБ-ын аюулгүй ажиллагаанд судалгаа шинжилгээ хийж тайлагнана. /Эхний хагас жилд: Албаны дүрмийн 3.3.7-ийн дагуу “Чингис хаан” ОУНБ-ын аюулгүй ажиллагаанд судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт гарган Зам, тээврийн хөгжлийн сайдад тайлагнана/

Биелэлт: ИНЕГ-ын Нислэгийн аюулгүй ажиллагаа хяналт зохицуулалтын албанд “Чингис хаан” ОУНБ-ын аюулгүй ажиллагаанд судалгаа шинжилгээ хийсэн талаарх мэдээллийг ирүүлэх албан бичиг хүргүүлэв. /2022.06.13-ны 45/22 тоот/ ИНЕГ-ын 2022.06.23-ны 03/1145 тоот бичгээр ирсэн хариуг үндэслэн судалгаа шинжилгээ хийх, дүгнэлт гаргах ажиллагаа явагдсан. Тайлан дүгнэлтийг 2022.12.19-ний 88/22 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн сайдад танилцуулахаар хүргүүлсэн. 70% /Удаашралтай хэрэгжсэн тул үнэлгээ бууруулав/

3/ 4.3. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу мэдээллийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтоосон хугацаанд байршуулна.

Биелэлт: 70% /Зарим мэдээлэл дутуу тавигдсан тул үнэлгээ бууруулав/

4/ 5.3. Шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай багаж тоног, төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслэл зэргийн нөөцийг бүрдүүлж, байнгын бэлэн байдалд байлгана.

Биелэлт: Холбогдох журам, нормын дагуу хяналт тавин шаардлагатай иж бүрдэл, хэрэгсэл, төхөөрөмжийн судалгааг гаргасан.

Онцгой байдлын улмаас энэ оны төсөвт хэмнэлт хийгдэж, ямар ч тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах ажиллагаа нэмж хийгдээгүй байна.

Судалгаагаар 2022 онд Хөдөлмөр хамгаалал, нормын хувцас 6 шинжээчид зориулж 3990000, багаж хэрэгсэлд 21100000, бусад 1700400 төгрөг, нийт 26790400 төгрөгний зардал шаардлагатай байсан. Өмнөх онуудад авч хэрэглэж буй тоног төхөөрөмж, хэрэгслүүдийг ажлын бэлэн байдалд байлгаж байна. 70%

5/ 7.1. Ажилтан, албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэн албан хэрэг хөтлөлтөд ашиглаж, тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог бүрэн хэмжээнд нэвтрүүлэх.

/Хагас жилийн байдлаар: Удирдах ажилтанд тоон гарын үсгийн хэрэглээг бүрэн хэмжээнд нэвтрүүлж, бусад ажилтны тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлсэн байна. Тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог нэвтрүүлсэн байна/

Биелэлт: Үйл ажиллагааны онцлогоос хамаарч зөвхөн албаны даргын тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлж албаны бичиг хэрэг хөтлөлтөд ашиглаж байна. Токен төхөөрөмж захиалан авч, гэрээ байгуулан баталгаажуулсан. Шаардлагатай тохиолдолд нэмэлт төхөөрөмж QR код авч ашиглахаар шийдвэрлэв. 70%



6/7.2. Албаны чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд дэвшилтэд техник технологи, инновацийн талаар туршлага судлах, хамтын ажиллагаа өрнүүлэх, судалгаа хийх. /Жилийн эцсийн байдлаар: Нийтдээ 2-оос доошгүй судалгааны ажлын эцсийн тайланг яаманд танилцуулсан байна/

Биелэлт: Албаны үндсэн чиг үүрэг осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд ашиглах агаарын хөлгийн нислэгийн өгөгдөл болон яриа бичлэгийн төхөөрөмжийн /FDR/CVR/ бичлэгийг тайлж унших ажиллагааг сайжруулах зорилгоор

1. Шинэ програм хангамж,

2. Тоног төхөөрөмж, техник хэрэгслүүдийг судлаж, нэвтрүүлэх ажиллагаа хийгдэж байна.

Канад улсын Planesceines компаний шинэ технологи болох FAV-INV шинэ системийн талаарх судалгаа хийсэн.

АНУ-ын Honeywell, L3-Com-ын тоног төхөөрөмжүүдээс худалдан авахаар судалгаа хийв. Цаашид нислэгийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, шинжлэн шалгах ажиллагаанд нэвтрүүлэх зорилт тавиад байна.

Санхүүгийн асуудлаас болж шинэ програм хангамж, төхөөрөмж худалдан авах ажиллагаа шийдэгдээгүй, хойшлогдсон байна. 70%

2.2. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
6	3	-	-	-	3	-	100%

2.3. Сайдын зөвлөлийн хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
3	1	1	-	-	1	-	85%

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

1/ 2022.04.22 №14 Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийн талаар

2. Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийн явцыг 14 хоног тутам Зам, тээврийн шуурхай хуралдаанд танилцуулж байхыг Иргэний нисэхийн ерөнхий газар (С.Мөнхнасан), Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба (Ж.Цолмон) тус тус даалгав

Биелэлт: ИНЕГ, НААХЗА болон МИАТ ХК-ний удирдлагуудтай уулзалт ярилцлага тогтмол хийн, зөвлөмжийн биелэлтийн талаар харилцан зөвшилцөж, зөвлөмжийн биелэлтийг хугацаатай болгов.

2022.04.15-нд зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэж, МИАТ ХК-тай холбоотой 2 зөвлөмжийг 100% хэрэгжсэн гэж үзсэн. Тайлангийн хугацаанд шинээр 6 зөвлөмж

гарсан, хуучин 8, нийт 14 зөвлөмжийн биелэлтийг цаг тухайд нь дүгнэн сар бүр танилцуулдаг байсан бөгөөд одоогоор 14 хоног тутам танилцуулахаар болов. 2022.01.20-ны 03/22 тоот, 2022.02.01-ний 09/22, 2022.03.04-ны 23/22, 2022.04.15-ны 35/22 тоот, 2022.06.03-ны 42/22 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн сайдад, 41/22-оор ИНЕГ-т, 43/22 тоотойр ИНБХЗГ-т тус тус танилцуулсан.

Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг зөвлөмж өгөгдсөн байгууллагуудаас сар бүр авч “Зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэх журам”-ын дагуу үнэлэлт, дүгнэлт хийж байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны эхний 7 сарын байдлаар 2022.07.27-ны 53/22 тоот албан бичгээр ЗТХ-ийн сайдад, 54/22 тоот албан бичгээр ИНБХЗГ-т, 52/22 албан бичгээр ИНЕГ-т, 2022 оны 8 дугаар сарын байдлаар 2022.08.26-ны 58/22 тоотойр ИНЕГ-т, 59/22-р Зам, Тээврийн хөгжлийн сайдад, 60/22-р ИНБХЗГ-т тус тус хүргүүлэв.

Засгийн газрын тогтоол, тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 14 хоног тутам шинэчлэн гаргаж ХШҮДАГ-т мэдээлж байна. 70%

2.5. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт дараах байдалтай байна.

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээлэл	10	4	1	2	-	3	75.7
Хүний нөөцийн мэдээлэл	6	6	-	-	-	-	100.0
Нийт	16	10	1	2	0	3	86.9

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

1/ 1.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж

Биелэлт: 30%

2/ Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ

Биелэлт: Журмын дагуу өргөдөл, гомдлын шийдвэрлэж ирсэн. Тайлангийн хугацаанд тус албанд 2 өргөдөл ирсэн байна, мэдээг улирал бүр ХШҮДАГ-т тайлагнадаг. 30%

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

НТОЗШША нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, яамны БТГ-аар хянуулан баталгаажуулсан байна.

Харьяа байгууллагуудын 2022 оны үйл ажиллагааг дүгнэх зорилгоор БТГ-аас тус албаны эдийн засаг, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа

болон үндсэн үйл ажиллагаатай холбоотой шалгуур үзүүлэлтийн төсөл боловсруулсан боловч албажуулж батлуулаагүй тул үнэлгээнд оруулж дүгнэсэнгүй.

2. Хэрэгжилтийн байдал:

- 1) НТОЗШША-ны 2022 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, СЗХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **87,8%**-тай үнэлэгдсэн байна.
- 2) НТОЗШША-ны 2021 он, 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн зөвлөмжөөс дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:
 - 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг энэ оны 12 сард багтаан баталж, албажуулах;
 - Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацааны дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;
 - “Чингис хаан” ОУНБ-ын аюулгүй ажиллагаанд судалгаа шинжилгээ хийж тайлагнах;
- 3) Цахим хуудасны үйл ажиллагааг шинэчлэн сайжруулах, Ажилтан, албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэн албан хэрэг хөтлөлтөд ашиглаж, тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог бүрэн хэмжээнд нэвтрүүлэх, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу мэдээллийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтоосон хугацаанд байршуулах ажлууд удаашралтай хэрэгжиж байна.
- 4) 2021 онд шинжлэн шалгах ажиллагааны 5 эцсийн тайлан, 1 урьдчилсан тайлан гаргаж байсан бол 2022 онд шинжлэн шалгах ажиллагааны 2 урьдчилсан тайлан, 1 эцсийн тайлан гаргаж ажилласан байна. Өөрөөр хэлбэл 2022 онд бүртгэгдсэн осол, зөрчлийн тоо нь өмнөх оноос нэмэгдсэн боловч хийгдсэн шинжлэн шалгах ажиллагаа буурсан байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. 2023 оны төлөвлөгөөнд тогтмол хийдэг ажлуудаас гадна тус албаны дүрмэнд заасан “Нислэгийн аюулгүй ажиллагааг сайжруулах зорилгоор судалгаа, шинжилгээ хийн дүгнэлт гаргах”, “Агаарын тээврийн 1-2 байгууллагыг сонгон үйл ажиллагаанд нь судалгаа, шинжилгээ дүгнэлт гаргах” зэрэг ажлыг нэмж оруулан Зам, тээврийн хөгжлийн сайдад танилцуулах;


2. Сул байгаа оронд тоонд албан тушаалын тодорхойлолтод тавигдсан шаардлагыг бүрэн хангасан хүнийг сонгон шалгаруулах замаар сул орон тоог яаралтай нөхөх, албан тушаалтан, ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэшүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах;

3. Ажилтан, албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэн албан хэрэг хөтлөлтөд ашиглаж, тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог бүрэн хэмжээнд нэвтрүүлэх, цахим хуудсаа шинэчлэн сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх;

4. Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг шинэчлэн баталсан журмын дагуу дүгнэн тайланг улирал бүр Зам, тээврийн хөгжлийн яаманд ирүүлэх;

ТАНИЛЦСАН:

САЙД



С.БЯМБАЦОГТ

ДЭД САЙД


Л.ХАЛТАР

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА




С.БАТБОЛД

ИНБХЗГ-ЫН ДАРГА



Ч.МӨНХТУЯА

НТОЗШША-НЫ ДАРГА



Ж.ЦОЛМОН

ХЯНАСАН:

ХШУДАГ-ЫН ДАРГА



А.МӨНХБАТ

БОЛОВСРУУЛСАН:

ХШУДАГ-ЫН ШИНЖЭЭЧ




Д.БАЯРМАА



НТОЗШША-НЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

№	Хяналтанд байх арга хэмжээ	2022 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Биелэлт /Хувиар/								
				Дундаж хувь	100	90	70	50	30	0	Хугацаа болоогүй	Хучингүй болсон
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	19	19	86.8	10	1	8	-	-	-	-	-
2	Сайдын тушаалын биелэлт	6	3	100.0	3	-	-	-	-	-	3	-
3	СЗХ-аас гарсан шийдвэрийн биелэлт	3	3	85.0	1	-	1	-	-	-	1	-
4	Ил тод нээлттэй байдлын үнэлгээ	16	13	86.9	10	-	1	-	2	-	3	-
Нийт		44	37	87.8	24	1	10	-	2	-	7	-

НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮНГ ГРАФИКААР ҮЗҮҮЛБЭЛ:





НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2022.07.04

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /НТОЗШША/-ны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан "Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

НТОЗШША-ны 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, СЗХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **89.1%**-тай үнэлэгдсэн байна.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. НТОЗШША-ны даргын 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
19	10	1	3	-	2	-	3	85%

НТОЗШША нь 2022 онд 19 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нийт 19 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 10 арга хэмжээ, 90%-ийн биелэлттэй 1 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 3 арга хэмжээ, 30%-ийн биелэлттэй 2 арга хэмжээ буюу хэрэгжилт дунджаар 89,7%-тай байна.

Хэрэгжилт хангалтгүй 2 арга хэмжээ:

1/ 2.3. "Чингис хаан" ОУНБ-ын аюулгүй ажиллагаанд судалгаа шинжилгээ хийж тайлагнана. /I-II улирал. Албаны дүрмийн 3.3.7-ийн дагуу "Чингис хаан" ОУНБ-ын аюулгүй ажиллагаанд судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт гарган Зам, Тээврийн хөгжлийн сайдад тайлагнана/

Биелэлт: ИНЕГ-ын Нислэгийн аюулгүй ажиллагаа хяналт зохицуулалтын албанд "Чингис хаан" ОУНБ-ын аюулгүй ажиллагаанд судалгаа шинжилгээ хийсэн



талаарх мэдээллийг ирүүлэх албан бичиг хүргүүлсэн. /2022.06.13-ны 45/22 тоот албан бичиг/

Тухайн албан тоотын хариуг үндэслэн дүгнэлт гаргаж, судалгаа шинжилгээ хийн ЗТХЯ-д тайлагнана. 30%

2/ 7.1. Ажилтан, албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэн албан хэрэг хөтлөлтөд ашиглаж, тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог бүрэн хэмжээнд нэвтрүүлэх.

/Хагас жилийн байдлаар: Удирдах ажилтанд тоон гарын үсгийн хэрэглээг бүрэн хэмжээнд нэвтрүүлж, бусад ажилтны тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлсэн байна. Тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог нэвтрүүлсэн байна/

Биелэлт: Албаны даргын тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлж эхэлсэн. 1 ширхэг токен төхөөрөмж захиалан авч, гэрээ байгуулан баталгаажуулаад байна. 30%

2.2. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
6	3	-	-	-	3	-	100%

2.3. Сайдын зөвлөлийн хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
3	2	1	-	-	-	-	90%

2.5. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт дараах байдалтай байна.

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээлэл	8	3	2	0	0	1	88.00
Хүний нөөцийн мэдээлэл	6	5	1	0	0	0	95.00
Нийт	38	8	3	0	0	1	91.82

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

НТОЗШША нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, яамны БТГ-аар хянуулан баталгаажуулсан байна.

Тус албаны 2022 оны эдийн засаг, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа болон үндсэн үйл ажиллагаатай холбоотой шалгуур үзүүлэлтийн төлөвлөгөөг яамнаас боловсруулж хүргүүлсний дагуу ИНЕГ-аас шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар хүснэгтээр ирүүлснийг хавсаргав.

2. Хэрэгжилтийн байдал:

1) НТОЗШША-ны 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, СЗХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **89.1%**-тай үнэлэгдсэн байна.

2) НТОЗШША-ны 2021 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн зөвлөмжөөс дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг энэ оны 12 сард багтаан баталж, албажуулах;
- Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацааны дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;

3) “Чингис хаан” ОУНБ-ын аюулгүй ажиллагаанд судалгаа шинжилгээ хийж тайлагнах, Ажилтан, албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэн албан хэрэг хөтлөлтөд ашиглаж, тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог бүрэн хэмжээнд нэвтрүүлэх ажлууд удаашралтай хэрэгжиж байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. “Чингис хаан” ОУНБ-ын аюулгүй ажиллагаанд судалгаа шинжилгээ хийж тайлагнах, Ажилтан, албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэн албан хэрэг хөтлөлтөд ашиглаж, тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог бүрэн хэмжээнд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх;

2. Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийн явцыг 14 хоног тутам Зам, тээврийн сайдын шуурхай хуралдаанд, тайланг улирал тутам дүгнэж, сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулах;


ТАНИЛЦСАН:

САЙД



Л.ХАЛТАР



ДЭД САЙД		Ж.БАТ-ЭРДЭНЭ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА		С.БАТБОЛД
ИНБХЗГ-ЫН ДАРГА		Ч.МӨНХТУЯА
НТОЗШША-НЫ ДАРГА		Ж.ЦОЛМОН
ХЯНАСАН:		
ХШУДАГ-ЫН ДАРГА		М.ЭНХБОЛД
БОЛОВСРУУЛСАН:		
ХШУДАГ-ЫН ШИНЖЭЭЧ		Д.БАЯРМАА




НТОЗШША-НЫ 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

№	Хяналтанд байх арга хэмжээ	2022 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Биелэлт /Хувиар/								
				Дундаж хувь	100	90	70	50	30	0	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	19	16	85.0	10	1	3	-	2	-	3	-
2	Сайдын тушаалын биелэлт	6	3	100.0	3	-	-	-	-	-	3	-
3	СЗХ-аас гарсан шийдвэрийн биелэлт	3	3	90.0	2	-	1	-	-	-	-	-
4	Ил тод нээлттэй байдлын үнэлгээ	12	11	91.8	8	-	3	-	-	-	1	-
Нийт		40	33	89.1	23	1	7	-	2	-	7	-



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДУНГ ГРАФИКААР ҮЗҮҮЛБЭЛ:

Дундаж хувь 89.1%



Нислэг техникийн осол хэргийг шинжлэн шалгах албаны 2022 оны төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт

12/30/2021

№	Үйл ажиллагаа	Суурь үзүүлэлт /2021 он/	Төлөвлөсөн /2022 он/	Гүйцэтгэл	Чанарын үзүүлэлт /харьцуулалт/	Тайлбар
1. Эдийн засгийн үзүүлэлт						
1.1.	Орлого	-	-			
1.2.	Зардал	-	-			
1.3.	Ашиг/алдагдал	-	-			
2. Нийгмийн үзүүлэлт						
2.1.	Ажиллагсдын тоо	7	8	7		
2.1.1.	Захиргааны	1	1	1		
2.1.2.	Үндсэн үйл ажиллагаатай холбоотой	6	6	6		
2.2.	Ажилчдын шилжилт хөдөлгөөн	1	1	1		
2.3.	Ажилчдын дундаж цалин	1500000	1650000	1650000		
2.4.	Хөдөлмөрийн бүтээмж					
2.5.	Ажилчдын мэргэжил дээшлүүлсэн байдал	0	2	0		
2.6.	Ажилчдын нийгмийн асуудлыг шийдсэн байдал	0	0	0		
2.7.	Авлига ашиг сонирхолтой холбоотой үзүүлэлт	0	0	0		
3. Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үзүүлэлт						
3.1.	Үйлдвэрлэлийн ослын тоо	0	0	0		
3.1.1.	Үйлдвэрлэлийн осолд өртсөн хүний тоо	0	0	0		
3.1.2.	Нийт хурц хордлогын тоо	0	0	0		
3.2.	Ажилтнуудын эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байдал	0	7	0		
3.3.	Ажилчдын ажлын байрны аттестатчлал, хөдөлмөрийн нөхцөл сайжруулалт	0	-	0		
4. Аюулгүй ажиллагаатай холбоотой үзүүлэлт						
4.1.	Нислэг техникийн осол зөрчил	24		15		
4.1.1.	Монгол Улсад үйлдэгдэж буй агаарын хөлөгт ногдох	1,2				
4.1.2.	Өнгөрөлтийн нислэг үйлдэж буй	0,44				
4.2.	Нислэг техникийн осол	0		0		
4.2.1.	1000 нислэгт ногдох зөрчил	4,4				
4.2.2.	1000 нислэгт ногдох ноцтой зөрчил	0		0		
4.2.3.	Агаарын хөлгийн техникийн байдлаас болж гарч буй зөрчил	18		3		
4.2.4.	Хүний хүчин зүйлээс шалтгаалан гарч буй зөрчил	6		1		
4.2.5.	Бусад	0		0		
4. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой үзүүлэлт						
5.1.	Хяналт шалгалтын тоо					



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2021.12.13

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /НТОЗШША/-ны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

НТОЗШША-ны 2021 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, СЗХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **90,5%**-тай үнэлэгдсэн байна. /Хүснэгт 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. НТОЗШША-ны даргын 2021 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
18	14	2	1	1	-	-	-	94.4%

НТОЗШША нь 2021 онд 18 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нийт 18 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 15 арга хэмжээ, 90%-ийн биелэлттэй 2 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 1 арга хэмжээ, 50%-ийн биелэлттэй 1 арга хэмжээ буюу хэрэгжилт дунджаар 94.4%-тай байна.

Хэрэгжилт хангалтгүй 2 арга хэмжээ:

1/ 4.1. НТОЗШША-ны 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулах. /1 улирал. НТОЗШША-ны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, батлуулсан байна/

Биелэлт: НТОЗШША-ны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, 1-р сард Зам, тээврийн хөгжлийн яамны ХШҮДАГ-т хянуулахаар цахимаар хүргүүлсэн. Хянаж дууссаны дараа албан тоотгоор 2021 оны гүйцэтгэлийн



төлөвлөгөөг 2 хувь гарган албаны даргаар баталгаажуулан ЗТХЯ-нд хүргүүлсэн.
/2021.04.08-ны 60/21 тоот, 2021.05/ 50%

/Хугацаа хоцроосон, баталгаажуулаагүй тул үнэлгээг буурууллаа/

2/ 3.2. Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, Зам, тээврийн хөгжлийн сайдад тайлагнах /I, IY улирал. Албаны дүрэм, журмын биелэлтийг хангана. Зам, тээврийн хөгжлийн сайдад танилцуулсан байна/

Биелэлт: Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийн талаар танилцуулга, холбогдох материал, шийдвэрийн төслийг 2021.05.03-нд 67/21 тоот албан бичгээр хүргүүлсэн.

2021.05.28-нд сайдын зөвлөлийн хуралд зөвлөмж болон осол зөрчлийг шинжлэн шалгасан тайлангийн талаар танилцуулга хийсэн. ИНЕГ-аас зөвлөмжийн хэрэгжилтийг хариуцах эзэн, биелүүлэх хугацааг тодорхойлж ирүүлсэн тайланг нэгтгэн судалж, дүгнэн, дахин зөвлөмжийн хэрэгжилтийн талаар сайдын зөвлөлийн хуралд танилцуулахаар тайлан, холбогдох материал, шийдвэрийн төслийг бэлтгэж 76/21 тоот албан бичгээр 2021.06.14-нд ЗТХЯ-нд хүргүүлсэн. Зөвлөмжийн биелэлтийн талаар ЗТХЯ-нд 05/21, 12/21, 14/21, 16/21, 36/21, 37/21, 39/21, 58/21, 102/21 тоот албан бичгүүдээр тус тус хүргүүлж тайлагнасан. Зам, тээврийн хөгжлийн сайдын 03, 04 албан даалгаврын хэрэгжилтийг 72/21, 73/21 тоот албан бичгээр 2021.06.14-нд ЗТХЯ-д хүргүүлсэн. 70%

/Сайдын зөвлөлийн хуралдаанаас дахин танилцуулах үүрэг өгч буцаасан тул үнэлгээг бууруулсан/

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
1	1	-	-	-	-	-	100.0%

2.3. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
10	5	2	-	-	3	-	91.4%

Хэрэгжилт хангалтгүй 1 арга хэмжээ:

1/ Цахим болон тоон гарын үсэгт шилжүүлэх тухай 2020.08.21 №160

1. Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичиг, албан хэрэг хөтлөлтийг 2021.01.01-ний өдрөөс тоон гарын үсэгт шилжүүлэн цахимаар мэдээлэл солилцох талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах

Биелэлт: Тушаалын дагуу цахим гарын үсэгт шилжихээр токен төхөөрөмжийг захиалсан. Цахим системд системийн Эбле программд 2 хүний нэвтрэх эрх



нээлгэж, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан мэдээллийг цаг тухайд нь оруулаад байна. 70%

2.4. Сайдын зөвлөлийн хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
4	2	1	1	-	-	-	75,0

Хэрэгжилт хангалтгүй 1 арга хэмжээ:

1/ Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийн талаар 2020.10.19 №20

3. Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийн байдал болон зөвлөмжийн хэрэгжилтэд хариуцлагагүй хандсан байгууллагын удирдлагын талаарх тайлбар, зөвлөмжийн хэрэгжилтийг тодорхой хувиар гаргаж улирал тутам тайлагнаж ажиллахыг Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /Ж.Цолмон/-д үүрэг болгов.

Биелэлт: Өмнөх оны хэрэгжээгүй байсан 14 аюулгүй ажиллагааны зөвлөмжүүдээс 50 хувиас доош үнэлэгдсэн зөвлөмж байхгүй, хэрэгжих шатандаа 2 зөвлөмж байгаа нь хувь хүн, албан тушаалтнаас шууд хамаарахгүй, цар тахалын үеийн нөхцөл байдал болон хөрөнгө оруулалт, санхүүгийн нөхцөл байдлаас болсон байна гэж үзсэн.

Сүүлийн хугацаанд ИНЕГ-ын удирдлага зохион байгуулалтанд өөрчлөлт орж, аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар идэвхи санаачлагатай, тодорхой төлөвлөгөө зорилготой ажиллаж, зарим үр дүнд хүрч байгаа тул энэ удаад хариуцлага тооцох албан тушаалтныг тодорхойлоогүй болно. 30%

2.5. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт дараах байдалтай байна.

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Шаардлагагүй	
Үйл ажиллагааны ил тод байдал	8	3	2	-	-	3	88,0
Хүний нөөцийн ил тод байдал	5	3	2	-	-	-	88,0
Нийт	13	6	4	-	-	3	88,0

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

НТОЗШША нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, ХШҮДАГ-ын хянуулсан боловч баталгаажуулаагүй байна.



2. Хэрэгжилтийн байдал:

1) НТОЗШША-ны 2021 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, СЗХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 90,5%-тай үнэлэгдсэн байна.

2) НТОЗШША-ны 2020 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн зөвлөмжөөс дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Шинжлэн шалгасан тайлангуудыг байгууллагын цахим хуудсанд байрлуулах;
- ЗТХ-ийн сайдын 2020 оны 03 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах,

3) Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг улирал тутам ЗТХЯ-д ирүүлж байгаа боловч сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулаагүй байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг энэ оны 12 сард багтаан баталж, албажуулах;

2. Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацааны дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгайн хэрэгжүүлэх;

3. Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг улирал тутам дүгнэж, сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулах;

ТАНИЛЦСАН:

САЙД

Л.ХАЛТАР

ДЭД САЙД

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

ИНБХЗГ-ЫН ДАРГА

Ч.МӨНХТУЯА

НТОЗШША-НЫ ДАРГА

Ж.ЦОЛМОН

ХЯНАСАН:

ХШУДАГ-ЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

БОЛОВСРУУЛСАН:

ХШУДАГ-ЫН ШИНЖЭЭЧ

Д.БАЯРМАА




НТОЗШША-НЫ 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

№	Хяналтанд байх арга хэмжээ	2021 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Биелэлт /Хувиар/								
				Дундаж хувь	100	90	70	50	30	0	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	18	18	94.4	14	2	1	1	-	-	-	-
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	1	1	100.0	1	-	-	-	-	-	-	-
3	Сайдын тушаалын биелэлт	10	7	91.4	5	-	2	-	-	-	3	-
4	СЗХ-аас гарсан шийдвэрийн биелэлт	4	4	75.0	2	-	1	-	1	-	-	-
5	Ил тод нээлттэй байдлын үнэлгээ	13	10	88.0	6	-	4	-	-	-	3	-
Нийт		46	40	90.5	28	2	8	1	1	-	6	-



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮНГ ГРАФИКААР ҮЗҮҮЛБЭЛ:

Дундаж хувь 90.5%





НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2021.01.06

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /НТОЗШША/-ны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн сайдын 2017 оны 259 дүгээр тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

НТОЗШША-ны 2020 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, СЗХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **88,6%**-тай үнэлэгдсэн байна. /Хүснэгт 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. НТОЗШША-ны даргын 2020 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Нийт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
Тусгайлан олгосон чиг үүрэг	7	4	3	-	-	-	87,1
Нийтлэг чиг үүрэг	11	8	-	1	-	2	92,2
Нийт	18	12	3	1	-	2	90,0

НТОЗШША нь 2020 онд 18 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нийт 18 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 12 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 3 арга хэмжээ буюу хэрэгжилт дунджаар 90,0%-тай байна.

Хэрэгжилт хангалтгүй 1 арга хэмжээ:



1/ 4.5.2. Хууль тогтоомж, тогтоолын шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах /Жилийн эцэст. Өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг гарган ЗТХЯ-ны ТЗУГ, ХШҮДАГ-т тайлагнана/

Биелэлт: Хууль тогтоомж, тогтоолын шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг жилийн эцсээр гарган 2020.12.20-нд ЗТХЯ-ны ХШҮДАГ-ын мэргэжилтэнд имэйлээр болон албан тоотоор хүргүүлсэн. Мөн ил тод байдлын тайлан, СЗХ-ын шийдвэрийн биелэлтийг 2020 оны байдлаар гарган цаг тухайд нь тайлагнаж ажиллав. 30% /ЗТХ-ийн сайдын 2020 оны 03 дугаар албан даалгавар хэрэгжээгүй тул үнэлгээг буурууллаа/

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
1	1	-	-	-	-	-	100,0

2.3. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
11	6	-	-	-	5	-	100,0

2.4. Сайдын зөвлөлийн хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
4	-	1	2	-	1	-	43.3

Хэрэгжилт хангалтгүй 2 арга хэмжээ:

1/ Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийн талаар 2020.10.19 №20

3. Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийн байдал болон зөвлөмжийн хэрэгжилтэд хариуцлагагүй хандсан байгууллагын удирдлагын талаарх тайлбар, зөвлөмжийн хэрэгжилтийг тодорхой хувиар гаргаж улирал тутам тайлагнаж ажиллахыг Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /Ж.Цолмон/-д үүрэг болгов.

Биелэлт: Аюулгүй ажиллагааны зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу улирал тутам хэрэгжилтийг ИНЕГ-т хүргүүлэн, ажиллаж байна. 2020 онд



хэрэгжилт хангалтгүй байгаа аюулгүй ажиллагааны зөвлөмжийг албаны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан. 30%

2/ 4. Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас гаргасан хэрэгжээгүй 14 зөвлөмжийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөрт багтаан хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргаж 2020 оны 11 дүгээр сарын 01-ний дотор багтаан Зам, тээврийн хөгжлийн яаманд ирүүлэхийг Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /Ж.Цолмон/-т, Иргэний нисэхийн ерөнхий газар /Л. Бямбасүрэн/-т тус тус даалгав.

Биелэлт: Тус албанаас аюулгүй ажиллагааны зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу улирал тутам хэрэгжилтийг нэгтгэн, тайлагнаж ажиллаж байна. 2020 онд хэрэгжүүлэх 25 арга хэмжээнээс хангалтгүй 6 арга хэмжээг албаны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан. 30%

2.5. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт дараах байдалтай байна.

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Шаардлагагүй	
Үйл ажиллагааны ил тод байдал	9	5	1	-	-	3	95,0
Хүний нөөцийн ил тод байдал	5	3	2	-	-	-	88,0
Нийт	14	8	3	-	-	3	91,8

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

НТОЗШША нь 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа ХШҮДАГ-ын өгсөн зөвлөмжийн дагуу агуулга нь давхардсан арга хэмжээнүүдийг нэгтгэн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой болгон батлуулсан байна.

2. Хэрэгжилтийн байдал:

1) НТОЗШША-ны 2020 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, СЗХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 88,6%-тай үнэлэгдсэн байна.

2) ЗТХ-ийн сайдын 2020 оны 03 дугаар албан даалгавар хэрэгжээгүй тул НТОЗШША-ны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан "Хууль тогтоомж, тогтоолын шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах" ажлын үнэлгээг бууруулан 30% гэж, COVID-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хойшлогдсон олон улсын хэмжээний хурал, сургалтад оролцох 2 арга хэмжээг үнэлэх боломжгүй гэж үзлээ.

3) НТОЗШША-ны 2019 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн зөвлөмж болон тайлангийн хурлын үед сайдаас өгсөн үүрэг даалгавраас дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:



- Зам, Тээврийн хөгжлийн сайдын “Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хангалт, хяналтыг сайжруулах тухай” 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дүгээр албан даалгаврын дагуу 2016 оноос хойш гарсан нислэг техникийн зөрчлийн шалтгаан, нөхцөлд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид бүх шатанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 2020 оны 1 дүгээр сард багтаан Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулах /2020 оны 9 сард танилцуулсан/
 - Бүртгэлийн ECCAIRS программ хангамжийг сайжруулах, мэдээллийн санг нэмэгдүүлэх;
 - Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд НТОЗШША-аас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт, тайлагналт, хариуцлагын асуудлыг тусгах,
 - Иргэний нисэхийн осол, зөрчлийн мэдээлэлд тулгуурлан судалгаа хийх, судалгаанд үндэслэн урьдчилан сэргийлэх зөвлөмж өгч ажиллах;
 - Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах
- 4) Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан “Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийн талаар”-ийн талаар 2020.10.19-ний өдрийн 20 дугаар тэмдэглэлийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас Сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн хэрэгжилт хамгийн бага буюу 43,3%-иар үнэлэгдсэн байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2020 онд хэрэгжээгүй ажлуудыг бүрэн тусгаж, хүрэх түвшинг улирал бүрээр тодорхойлж, ЗТХЯ-аар хянуулж батлах;
2. Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийн байдал болон зөвлөмжийн хэрэгжилтэд хариуцлагагүй хандсан байгууллагын удирдлагын талаарх тайлбар, зөвлөмжийн хэрэгжилтийг тодорхой хувиар гаргаж, улирал тутам тайлагнаж ажиллах;
3. Иргэний агаарын хөлөгт тохиолдсон нислэгийн зөрчлийг бүртгэн “Мэдээллийн схем баталж, мэдээлэл дамжуулах тухай” ЗТХ-ийн сайдын 2018 оны 235 дугаар тушаалын дагуу ЗТХЯ-д мэдээлж ажиллах;

ТАНИЛЦСАН:

САЙД
ДЭД САЙД
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Л.ХАЛТАР
Ж.БАТ-ЭРДЭНЭ
С.БАТБОЛД

АГТБХЗГ-ЫН ДАРГА
НТОЗШША-НЫ ДАРГА

Ч.МӨНХТУЯА
Ж.ЦОЛМОН

ХЯНАСАН:

ХШҮДАГ-ЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

БОЛОВСРУУЛСАН:

ХШҮДАГ-ЫН ШИНЖЭЭЧ

Д.БАЯРМАА



**НТОЗШША-НЫ 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

№	Хяналтанд байх арга хэмжээ	2020 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Биелэлт /Хувиар/								
				Дундаж хувь	100	70	40	30	0	Үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	18	16	90.0	12	3	-	1	-	2	-	-
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	1	1	100.0	1	-	-	-	-	-	-	-
3	Сайдын тушаалын биелэлт	11	6	100.0	6	-	-	-	-	-	5	-
4	СЗХ-аас гарсан шийдвэрийн биелэлт	4	3	43.3	-	1	-	2	-	-	1	-
5	Ил тод нээлттэй байдлын үнэлгээ	14	11	91.8	8	3	-	-	-	3	-	-
Нийт		48	37	88.6	27	7	-	3	-	5	6	-



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮНГ ГРАФИКААР ҮЗҮҮЛБЭЛ:

Дундаж хувь 88.6%



№	дугаар	хугацаа	хувь
Тусгайлан олгосон			
1	3.1.1	1-12	100
2	3.1.2	1-12	100
3	3.2.1	1-12	70
4	3.2.2	1-3	100
5	3.2.3	1-12	70
6	3.3.1	1-12	100
7	3.3.2	1-12	70
Нийтлэг чиг үүрэг			
8	4.1.1	1-3	100
		6	
9	4.1.2	12	100
10	4.1.3	1-12	t
11	4.2.1	1-12	100
12	4.2.2	1-12	t
13	4.3.1	1-12	100
14	4.3.2	1-12	100
15	4.4.1	1-3	100
16	4.4.2	1-12	100
17	4.5.1	1-12	100
18	4.5.2	1-12	30
	100		12
	70		3
	30		1
	0		0
	t		2
	Дүн		90

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	90
Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	100
Сайдын тушаалын хэрэгжилт	100
СЗХ-аас гарсан шийдвэрийн биелэлт	43.3
Ил тод нээлттэй байдлын үнэлгээ	91.8



**НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ
АЛБАНЫ 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2020.01.10

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /НТОЗШША/-ны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн сайдын 2017 оны 259 дүгээр тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

НТОЗШША-ны 2019 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **97.2%**-тай үнэлэгдсэн байна. /Хүснэгт 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. НТОЗШША-ны даргын 2019 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс				Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%		
Нийт 17 арга хэмжээ	15	2	-	-	-	96.5%
Манлайллын 4 зорилт	4	-	-	-	-	100.0%
Нийт 21	19	2	-	-	-	97.1%

НТОЗШША-ны дарга Ж.Цолмон нь 2019 онд 21 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нийт 21 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 19 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 2 арга хэмжээ буюу хэрэгжилт дунджаар 97.1%-тай байна.

Бүрэн хэрэгжээгүй 2 арга хэмжээ:

1/ 1.1.2 Иргэний нисэхийн Багц дүрмийг Иргэний нисэхийн тухай Монгол улсын хууль, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын шаардлага, стандартад нийцүүлэхэд дэмжлэг үзүүлэх

/Одоо хэрэгжиж байгаа болон шинэчлэгдэн гарсан дүрмэнд шинжлэн шалгах ажиллагааны үр дүнг үндэслэн өөрчлөлт шинэчлэлт оруулах саналыг өгсөн байна/



Биелэлт: Иргэний нисэхийн багц дүрмүүдэд Олон улсын иргэний нисэхийн стандарт шаардлага, шинжлэн шалгах ажиллагаатай уялдаа холбоог сайжруулахад байнга анхаарч ажиллаж байна. ИНЕГ-ын Дүрмийн хэлтсээс 2019.06.10-ны өдөр ирүүлсэн ИНД-1 "Тодорхойлолт ба Товчлол", ИНД-91 "Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм", ИНД-115 "Сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт", ИНД-133 "Нисдэг тэрэгний дүүжин тээвэрлэлт", ИНД-137 "Хөдөө аж ахуйн зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт", ИНД-203 "Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах" зэрэг дүрмүүдийн англи, монгол хэл дээрх хувилбарыг судлан танилцаж, дүрмийн шинэчлэл, хэлэлцүүлэгт оролцон, орчуулга, үг хэллэгийн сонголт, найруулгыг шалгаж, санал тусгуулахаар бэлтгэж байна.

2/ 3.2.4. 2016 оноос хойш гарсан нислэг техникийн зөрчлийн шалтгаан, нөхцөлд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид бүх шатанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулан Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулах
Зорилтот түвшин 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дүгээр албан даалгавраар үүрэг өгсөн. Хугацаа: 2-р улирал

Биелэлт: Сайдын шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврын дагуу нисэх бүрэлдэхүүний судалгаа, осол болон ноцтой зөрчилд холбогдож байсан нисгэгч нарын судалгааг гарган Цаашид төрөөс нисэх бүрэлдэхүүний боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талаар бодлогын чанартай арга хэмжээ авах хэрэгтэй талаар саналыг 2019.04.10-ны өдрийн 46/19 тоот албан бичгээр сайдад хүргүүлсэн.
2019.10.21-ний 103/19 тоотгоор 2009-2019 оны аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх талаар албан тоот хүргүүлсэн 70%

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
16	15	-	-	-	1	-	100,0%

2.3. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
17	17	-	-	-	-	-	100,0

2.4. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт дараах байдалтай байна.

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Шаардлагагүй	
Үйл ажиллагааны ил тод байдал	9	4	2	-	-	3	90,0
Хүний нөөцийн ил тод байдал	5	3	2	-	-	-	88,0
Нийт	14	7	4	-	-	3	89.1



Гурав. Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

НТОЗШША нь 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа ХШҮДАГ-ын өгсөн зөвлөмжийн дагуу агуулга нь давхардсан арга хэмжээнүүдийг нэгтгэн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой болгон батлуулсан байна.

2. Хэрэгжилтийн байдал:

- 1) НТОЗШША-ны 2019 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 97,2%-тай үнэлэгдсэн байна.
- 2) НТОЗШША-ны 2018 он, 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн зөвлөмжөөс дараах зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:
 - Шинжлэн шалгасан ажиллагаанаас гаргасан нислэгийн аюулгүй ажиллагааны зөвлөмж, түүний хэрэгжилтийн байдлыг ЗТХ-ийн сайдад улирал бүр танилцуулан ажиллах;
 - Осол, зөрчлийн тайлангийн мэдээллийг боловсронгуй болгох арга хэмжээний хүрээнд хийгдэх Автокад, 3D Max програмын сургалтад 2 хүнийг хамруулах;
 - Бүртгэлийн ECCAIRS программ хангамжийг сайжруулах, мэдээллийн санг нэмэгдүүлэх;
- 3) Зам, Тээврийн хөгжлийн сайдын “Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хангалт, хяналтыг сайжруулах тухай” 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дүгээр албан даалгаврын дагуу 2016 оноос хойш гарсан нислэг техникийн зөрчлийн шалтгаан, нөхцөлд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид бүх шатанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулан 2009-2019 онд гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулахаар ирүүлсэн боловч Сайдын зөвлөлд танилцуулаагүй байна.
- 4) Үйл ажиллагааны болон хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудас, мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх ажил хангалтгүй хэвээр байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Зам, Тээврийн хөгжлийн сайдын “Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хангалт, хяналтыг сайжруулах тухай” 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дүгээр албан даалгаврын дагуу 2016 оноос хойш гарсан нислэг техникийн зөрчлийн шалтгаан, нөхцөлд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид бүх шатанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 2020 оны 1 дүгээр сард багтаан Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулах;
2. Салбарын эрсдлийн үнэлгээ хийх талаар ЗТХ-ийн сайдаас өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх;
3. Осол зөрчлийн тайлангийн мэдээллийг боловсронгуй болгох, агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага, нисэх бүрэлдэхүүн тус бүрээр сар бүр нэгдсэн тайлан, улирал бүр зөвлөмж ирүүлж байх;
4. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгт”-д заасан мэдээллийг



байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт тогтмол байрлуулж,
шинэчлэх;

ТАНИЛЦСАН:

САЙД

ДЭД САЙД

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

АТБХЗХ-ИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

НТОЗШША-НЫ ДАРГА

ХЯНАСАН:

ХШУДАГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

БОЛОВСРУУЛСАН:

ХШУДАГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.ЭНХ-АМГАЛАН

Л.ХАЛТАР

С.БАТБОЛД

Д.МЯГМАРСҮРЭН

Ж.ЦОЛМОН

М.ЭНХБОЛД

Д.БАЯРМАА



НТОЗШША-НЫ 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

№	Хяналтанд байх арга хэмжээ	2019 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Биелэлт /Хувиар/								
				Дундаж хувь	100	70	40	30	0	Үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	21	21	97.1	19	2	-	-	-	-	-	-
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	16	15	100.0	15	-	-	-	-	-	1	-
3	Сайдын тушаалын биелэлт	17	17	100.0	17	-	-	-	-	-	-	-
4	Ил тод нээлттэй байдлын үнэлгээ	14	11	89.1	7	4	-	-	-	3	-	-
Нийт		68	64	97.2	58	6	-	-	-	3	1	-



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮНГ ГРАФИКААР ҮЗҮҮЛБЭЛ:

Дундаж хувь 97,2%

